



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын  
Сайд нарын Зөвлөлийн

**ТОГТООЛ**

1962 оны 5 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 233

Улаанбаатар  
хот

Налайхыг хот болгосонтой хол-  
богдуулан авах зарим арга хэм-  
жээний тухай.

Б Н М А Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Налайх хотын гүйцэтгэх захиргааны орон тоог 19 нэгч, сарын, цалингийн фондыг 9470 төгрөгөөр хэвсрэлтийн ёсоор батласугай.

2. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н.ЛУВСАНЧОЙМБОЛ/-д даалгах нь:

а/налайхын худалдаа, нийтийн хоол, нийгэм хангамж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, ясли, кино, театр зэрэг соёл, гэгээрлийн байгууллагыг Налайх хотын гүйцэтгэх захиргаанд шууд харьяалуулсугай;

б/Улаанбаатар хотын 1962 оны төсвөөс Налайх хотыг тохижуулах зардалд 50 000 төгрөг, тэрэгний морь, тэрэг, тоног авах зардалд 5 000 төгрөгийг бохир усны машин нэгийн хамтаар олгосугай. ✓

3. Улаанбаатар хотын төсөвтэй шууд харьцан санхүүжилт байгаа налайхын худалдаа, үйлчилгээ, нийгэм хангамжийн салбар, соёл, гэгээрэл, эрүүлийг хамгаалах байгууллагуудын 1962 онд батлагдсан төсөвт зардлыг Налайх хотын гүйцэтгэх захиргаанаас шууд санхүүжүүлж байхаар, түүнд шилжүүлэн өгч, цаашид Налайх хотыг нийслэл хотын төвийн дотор биеэ

даасан тусгай төсөвтэй болгохыг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н.ЛУВСАНЧОЙМБОЛ/, Сангийн Яам /н.ДҮГЭРСҮРЭН/ нэрт даалгасугай.

4.Налайх хотын гүйцэтгэх захиргааны цалин, аж ахуйн зардлыг Сайд нарын Зөвлөлийн бэлтгэл хөрөнгөнөөс Улаанбаатар хотын 1962 оны төсөвт нэмэгдүүлэн олгохыг Сангийн Яам /н.ДҮГЭРСҮРЭН/-д даалгасугай.

5.Налайхын уурхайн ажилчдад зориулан тусгай эмнэлэг байгуулах, налайхын эмнэлгийг өргөтгөх тухайн асуудлыг энэ оны 3-р улиралд багтаан боловсруулж, Сайд нарын Зөвлөлд оруулахыг Эрүүлийг Хамгаалах Яам /н.ТУВААН/, Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н.ЛУВСАНЧОЙМБОЛ/, Аж Үйлдвэрийн Яам /н.ДАМДИН/-д даалгасугай.

6.Налайхын хувирт барааг түүний захиалгаар Төв бараа базаас шууд олгож байхыг Худалдаа, Бэлтгэлийн Яам /н.ДОРЖ-ГОТОВ/-т даалгасугай.

7.Налайхын хөдөлмөрчдийн үйлчилгээнд зориулан автобус 2, суудлын автомашин-такси 2-ыг энэ оны 6 дугаар сарын 1-ны дотор олгохоос гадна, цэвэрд Налайхын тээвэр, хөлбөмбөгийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авахыг Тээвэр, Хөлбөмбөгийн Яам /н.ЧИМИДДОРЖ/-д даалгасугай.

8.Налайхын үйлдвэрийн гал командад Налайх хотыг галын аюулаас хамгаалах үүргийг хариуцуулан ажиллуулж, нээрдэгдэх байцаагч нэгийн орон тоог нэмэгдүүлж эхийг Нийгмийг Аюулаас Хамгаалах Яам /н.БАНЗРАГЧ/-д даалгасугай.

9.Налайх хот дахь үйлчилгээний газруудыг нэгтгэн, үйлчилгээний тасаг байгуулж, аж ахуйн төсөсөн үндсэн дээр ажиллуулахыг Налайх хотын гүйцэтгэх захиргаанд зөвшөөрсүгэй.

Б.Н.М.А. Улсын Сайд нарын  
Зөвлөлийн 1-р орлогч дарга  
Б.Н.М.А. Улсын Сайд нарын  
Зөвлөлийн Хэрэг эрхлэх  
газрын дарга  
Хуулбар үнэн: Тогтоол сангийн  
эрхлэгч

МОЛ ОМЖАМЦ

БАДАРЧ

/ДАГВАДОРЖ/

*С.А.Дорж*

112

Сайд нарын Зөвлөлийн 1962  
оны 233 дугаар тогтоолын  
хавсралт.

Налайх хотын гүйцэтгэх захиргааны орон  
ноо, сарын утсандгийн фонд

№: Албан тушаалын нэр	: орон тоо	: сарын ца- лингийн фонд
1. Хотын гүйцэтгэх захиргааны дарга	1	1000
2. Худалдаа, үйлчилгээний байцаагч	1	500
3. Төлөвлөгч бөгөөд тоо бүртгэгч	1	500
4. Нарийн бичгийн дарга бөгөөд бичиг хэрэг	1	450
<u>Нийгэм-соёлын хэлтэс.</u>		
1. Хариуцлагатай нарийн бичгийн дарга бөгөөд нийгэм соёлын хэлтсийн дарга	1	850
2. Засаг захиргааны боловсон хүчний зааварлагч	1	500
3. Цэрэг, иргэний гэр бүлийн ажил эрхлэсэн төлөөлөгч	1	500
4. Соёл, гэгээрлийн <del>хэлтэс</del> байцаагч /дээд мэрэгжлийн/	1	600
5. Эрүүлийг хамгаалах асуудал эрхлэсэн байцаагч-их эмч	1	700
<u>Санхүү-аж ахуйн хэлтэс.</u>		
1. Хэлтсийн дарга	1	750
2. Ерөнхий нягтлан содогч-орлогын байцаагч	1	600
3. Төсөв, эхчүүдийн байцаагч	1	500
4. Комендант	1	350
5. Бичээч	1	340
6. Цэвэрлэгч	1	230
7. Галч	1	230
8. Мөшөөч	1	400
9. Зарлага	1	230
10. Сахиуу	1	240
Дүн	19	9470